



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/СР

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 01/19 дүгээр тогтоолоор батлагдсан "Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн 1.42, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 3/08 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 1.4.1, 1.4.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/621 тоот захирамж, тус газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Аялал жуулчлалын сайд нарын III хуралдааныг 2018 оны 07 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажилласугай.

2. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Аялал жуулчлалын сайд нарын III хуралдааныг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хуралдааныг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахад шаардагдах төсөв болох 24.031.000 / хорин дөрвөн сая гучин нэгэн мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д зөвшөөрсүгэй.

4. Арга хэмжээний үеэр хамтран ажиллах, гэрээ байгуулах байгууллагуудыг судалж, 2018 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс өмнө танилцуулахыг Ажлын хэсэг /Д.Жавхлан/-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

• 1150500187

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 07
сарын 09 өдрийн А/58 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

5284325 СБТ-8936 1118263502

МОНГОЛ УЛС, БНХАУ, ОХУ-ЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД НАРЫН
III ДУГААР ХУРАЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЖ,
ХАМТРАН АЖИЛЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга	Д.Жавхлан	/Мэдээлэл, сурталчилгааны хэлстийн дарга /
Гишүүд	Г.Азжаргал	/Олон нийтийн харилцаа хариуцсан мэргэжилтэн/
Гишүүд	З.Оюуншүр	/Хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн/

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 07
сарын 09 өдрийн А/58 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

5284125 057 & 2336 1118263502

МОНГОЛ УЛС, БНХАУ, ОХУ-ЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙД НАРЫН III ДУГААР ХУРАЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД
ШААРДАГДАХ ТӨСВИЙН ЗАДАРГАА

2018 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

Д/д	Зардлын зүйл	Тоо	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Тооцоо хийх хэлбэр
1	Тэрэлж Ворлд Ресорт дахь зочдын өдрийн хоол	100 хүн	50 000 төгрөг	5 000 000 төгрөг	Нэхэмжлэх
2	Цонжин болдог үзвэрийн тасалбар	80 хүн	8500 төгрөг	680 000 төгрөг	Нэхэмжлэх
3	Засаг даргын нэрэмжит оройн хүлээн авалт Асем вилла хаус	100 хүн	140 000 төгрөг	14 000 000 төгрөг	Нэхэмжлэх
4	Монгол үндэсний хувцас загварын үзүүлбэр /Торго салон/	1 коллекц	2 800 000 төгрөг	2 800 000 төгрөг	Нэхэмжлэх
5	Цайны замын хөшөөний суурь хийх, хөрсийг тэгшлэх, хөшөө зөөх крантай машин түрээс	1	980 000 төгрөг	980 000 төгрөг	Нэхэмжлэх
6	Тайз	1 ширхэг	300 000 төгрөг	300 000 төгрөг	Бэлнээр
7	Анонс	12м ²	8000 төгрөг	96 000	Бэлнээр
8	Шааран чимэглэл	1 ширхэг	120 000 төгрөг	120 000 төгрөг	Бэлнээр
9	Мод суулгахад шаардагдах ажлын бээлий, ёслолын бээлий, тууз, хайч	Тус бүр 20 ширхэг	100 000 төгрөг	100 000 төгрөг	Бэлнээр
НИЙТ 24 031 000 / хорин дөрвөн сая гучин нэгэн мянга / төгрөг					